

ЭРДЭНЭ РЕСУРС НЬ БАЯН ХӨНДИЙ АЛТНЫ ТӨСЛИЙН ЭЦСИЙН ТЭЗҮ-Г ЭХЛҮҮЛЭН, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ХАЙГУУЛ, ТЕХНИКИЙН ШИНЭ МЭДЭЭЛЛҮҮДИЙГ ТАНИЛЦУУЛАВ

Хэвлэлийн Мэдээ

Нова Скошиа, Халифакс хот
2020.1.13

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD | MSE:ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь Хөндий Алтны Төслийн (“Төсөл”) хараат бус эцсийн ТЭЗҮ (“Э-ТЭЗҮ” буюу “BFS”), анхан шатны инженерийн загварчлал (“АШИЗ” буюу “FEED”)-г боловсруулж эхэлснийг мэдээлэхэд таатай байна. Энэхүү эцсийн ТЭЗҮ дээр олон улсын болон Монголын мэргэжлийн байгууллагууд хамтран ажиллаж байна. Мөн Компанийн тусгай зөвшөөрлүүд, хайгуул, техникийн хөтөлбөрийн талаар шинэ мэдээллийг доорх хэвлэлийн мэдээнд тусгав.

Компанийн Эшлэл:

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Илээр олборлох боломжтой 3.7 г/т дундаж алтны агуулга бүхий 400,000 унц нөөцтэй орд, тухайн ордыг хүрээлсэн алтны дүүргийн хайгуулын боломжууд дээр суурилан Эрдэнэ Ресурс нь өндөр үр ашигтай шинэ олборлогч болох боломжийг бүрдүүллээ. 2020 оны дундуур танилцуулах Баян Хөндий Алтны Төслийн эцсийн ТЭЗҮ-ийг боловсруулж эхэлснээр бид алт олборлогч болоход нэг алхмаар ойртож байна. Эцсийн ТЭЗҮ-ийг Монголд үйл ажиллагаа эрхэлж байсан туршлагатай, төслийн санхүүжилт, тоног төхөөрөмжийг хангах боломжтой Азийн бүс нутагт төвлөрч ажилладаг зөвлөх байгууллагууд боловсруулж байна. Бид Төслийн тусгай зөвшөөрлүүдийг авах ажлыг амжилттай гүйцэтгэж: Баян Хөндий төслийн Монголын ТЭЗҮ-ийг тодорхой нөхцөлтэйгөөр батлуулж, Баян Хөндийн баяжуулах үйлдвэрийн технологийн ус хангамжийн нөөцийг бүртгүүлэн, дэд бүтцийн бүтээн байгуулалт, барилгыг барих газрыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгууллаа.”

“Түүнээс гадна, 2019 оны 4-р улиралд Хөндий алтны дүүргийн хайгуулыг үргэлжлүүлэх зорилгоор хайгуул ба техникийн судалгааны хөтөлбөрийг хэрэгжүүлж, Хөндий Алтны Дүүргийн эцсийн ТЭЗҮ-д багтах геотехникийн дээжлэлт хийв. Энэхүү хөтөлбөрөөр Алтан Нар, Улаан тусгай зөвшөөрлийн талбайд хэд хэдэн цооног өрөмдөж, Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд шинээр илрүүлсэн Хар Морь өндөр агуулга бүхий илэрцэд хөрсний дээжлэлт хийсний үр дүнг ойрын хугацаанд танилцуулахаар зорьж байна.”

Эцсийн ТЭЗҮ ба анхан шатны инженерийн загварчлал

2019 оны 12 сараас Эрдэнэ Ресурс нь тусгай зөвшөөрлүүд авах, төслийн санхүүжилт болон уурхайн дэд бүтцийг барих ТУЗ-ийн шийдвэр гаргахад шаардлагатай судалгаанууд болох эцсийн ТЭЗҮ (“BFS”), анхан шатны инженерийн загварчлал (“FEED”)-ын судалгаануудыг боловсруулж эхлээд байна. Эцсийн ТЭЗҮ нь National Instrument 43-101 эрдсийн төслийн тайлагналын стандартын дагуу боловсруулагдах бөгөөд ТЭЗҮ-д уурхайн загварчлал, боловсруулах үйлдвэр болон холбогдох дэд бүтцийн анхан шатны инженерийн загварчлал, гидрогеологийн судалгаа, хаягдлын удирдлагын нарийвчилсан төлөвлөгөө болон эдийн засгийн загварчлал зэрэг багтана. Эцсийн ТЭЗҮ-ийг 2020 оны дундуур танилцуулахаар төлөвлөж байна.

Дээрх судалгааг Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж байсан туршлагатай Канад, Австрали-Азийн мэргэжлийн зөвлөх байгууллагууд хамтран боловсруулна:

- Рома Групп Лтд (“**Roma**”) нь инженерчлэл, бизнес болон хөрөнгийн үнэлгээ, эрсдэлийн тооцоолол болон компанийн үнэлгээ, нэгдэл зэрэг үйл ажиллагаанд мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг бүс нутгийн тэргүүлэх байгууллага юм. Рома нь NI 43-101 стандартын дагуу эцсийн ТЭЗҮ-ийг боловсруулах бөгөөд гидрологи - гидрогеологи, геотехникийн судалгаа, зардлын тооцоолол, санхүүгийн загварчлалыг хийж гүйцэтгэнэ. Рома нь Хонг Конгийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй компани бөгөөд Монгол болон олон улсад уул уурхай, санхүүгийн байгууллагуудтай техникийн судалгаа, үнэлгээний төслүүдийг удирдан ажилласан туршлагатай.
- Эцсийн ТЭЗҮ, анхан шатны инженерийн загварчлалын тайланг боловсруулахад дараах дотоодын компаниуд хамтран ажиллаж байна. Үүнд: геотехник инженерчлэлийн Соил Трейд ХХК (“**Soil Trade**”), инженерчлэл болон барилга байгууламжийн Лобо Эрдэнэ ХХК (“**LOBO**”), уурхайн инженерчлэлийн зөвлөх байгууллага Прожект Майнинг ХХК (“**Project Mining**”), байгаль орчны зөвлөх байгууллага Эко Трейд ХХК (“**Eco Trade**”) багтаж байна. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын хууль, дүрэм журмуудад нийцүүлэн үйл ажиллагааны бүхий л үе шатанд дотоодын мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллахыг чухалчилсаар ирсэн.
- O2 Майнинг Лтд (“**O2**”) нь уурхайн төлөвлөлт ба загварчлал (уурхайн хаалт багтсан) дээр хамтран ажиллах бөгөөд Монголын барилгын тусгай зөвшөөрлүүд, олборлолтын бус дэд бүтцийн төлөвлөлтийг багтаах анхан шатны инженерийн загварчлал (“**FEED**”)-ыг хамтран боловсруулна. O2 нь Хонг Конг-д төвтэй, Австрали, Азийн орнуудын уурхай хөгжүүлэлтийн чиглэлээр мэргэшсэн компани бөгөөд Монгол улсад алт болон нүүрс олборлодог гурван уурхайн ашиглалт, үйл ажиллагаанд оролцож байсан туршлагатай компани юм.
- Ауралиа Майнинг Консалтинг (“**Auralia**”) нь эрдсийн нөөцийн эцсийн загварчлал болон уурхайн загварын оновчлолыг эцэслэнэ. Ауралиа нь Австрали улсын Перт хотод төвтэй уурхайн инженерчлэл, нөөцийн тооцоолол зэргээр мэргэшсэн зөвлөх байгууллага бөгөөд Баррик (“**Barrick**”), Гоулд Роуд Ресурсиз (“**Gold Road Resources**”) зэрэг алтны компаниудтай хамтран ажиллаж байсан туршлагатай компани юм.
- 360-Глобал Инк (“**360-Global**”) нь эцсийн ТЭЗҮ, анхан шатны инженерийн загварчлалд багтах баяжуулах үйлдвэрийн загварчлал, инженерчлэлийн судалгааг хийж гүйцэтгэнэ. 360-Глобал Инк нь Австрали, Филиппин улсуудад төвтэй бөгөөд Монгол болон олон улсад алтны боловсруулах үйлдвэрийн дэд бүтцийн загварчлал хийх үйлчилгээ үзүүлдэг туршлагатай байгууллага юм.
- Эй Ти Си Виллиамс РТУ Ltd (“**ATCW**”) нь эрдсийн хаягдлын байгууламж, удирдлага болон уурхайн хаалтын төлөвлөлтийг боловсруулж ажиллана. ATCW нь Австралийн Мелбурн хотод төвтэй бөгөөд Оюу Толгой зэрэг төслүүдэд хаягдлын тээвэр, хадгалалт, хаалт болон усны удирдлага зэрэг үйлчилгээ үзүүлсэн туршлагатай.
- Blue Coast Research Ltd (“**BCR**”) нь Хөндий Алтны Төслийн металлургийн судалгааг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. BCR нь алтны ордуудын судалгааг хийж гүйцэтгэж байсан туршлагатай бөгөөд өнөөг хүртэл Баян Хөндий болон Алтан Нар төслүүдийн металлургийн судалгааг хийж гүйцэтгэж байна.
- Sustainability East Asia, Ramboll, Эко Трейд компаниуд нь Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг үргэлжлүүлэн хийж гүйцэтгэнэ.

Техникийн судалгаа

Рома, Монгол дахь Соил Трейд ХХК нар хамтран Баян Хөндийн төлөвлөсөн ил уурхайн чулуулгийн бат бөх чанар, тогтвортой байдлын тооцооллын өгөгдлийг гаргах геотехникийн өрөмдлөгийн хөтөлбөрийг хийж гүйцэтгэсэн. Эдгээр өгөгдлүүдэд тулгуурлан Рома нь 1-р улиралд Баян Хөндий ил уурхайн ханын налууугийн тогтвортой байдлыг тодорхойлж, уурхайн загвар боловсруулна.

Металлургийн хөтөлбөрийн хүрээнд Blue Coast Research Ltd нь хүдрийн уусгалтын судалгаа, ус шавхалтын судалгаа, бутлагдах чанарын судалгааг хийж гүйцэтгэснээр эцсийн загвар ба тоног төхөөрөмжийн сонголтыг тодорхойлох боломжтой болно. Энэхүү судалгааны үр дүнг 1-р улирлын дундуур танилцуулах бөгөөд 360 Глобал-ын боловсруулж буй баяжуулах үйлдвэрийн загварт тусгана.

Өнгөрсөн 4-р улиралд Соил Трейд ХХК нь хөрсний инженер геотехникийн өрөмдлөгийн нарийвчилсан хөтөлбөрийг хийж гүйцэтгэсэн. Энэхүү судалгааны үр дүнг Баян Хөндий уурхайн байгууламжийн дэд бүтцийн загварыг боловсруулахад ашиглах бөгөөд түүнчлэн, байр зүйн зураглалын ажлыг гүйцэтгэсэн нь уурхайн байгууламжийн хөгжүүлэлт, Монголын тусгай зөвшөөрлүүдийг авахад шаардагдах материалын бүрдүүлэлт болж байгаа юм.

Тусгай зөвшөөрөл

2019 оны 4-р улиралд Компани нь голлох тусгай зөвшөөрлүүдийг авахад дараах алхмуудыг хийлээ:

- Баян Хөндийн Техник Эдийн Засгийн Үндэслэл (“Монголын ТЭЗҮ” буюу “MFS”): Компани нь Монголын Ашигт Малтмал, Газрын Тосны Газрын Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлөөс Монголын ТЭЗҮ-ийн нөхцөлт зөвшөөрлийг хүлээн авсан. Монголын ТЭЗҮ нь Хөндий Алтны Төслийн газар шорооны ажил эхлүүлэхэд шаардлагатай барилга байгууламжийн тусгай зөвшөөрлийг авахад суурь тооцоолол болно.
- Усны Нөөцийн Бүртгэл: Монгол улсын Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Яам нь Хөндий Алтны Төслийн дэд бүтэц, баяжуулах үйлдвэрийн технологийн усны нөөц болон ундаргын түвшинг баталж, бүртгэсэн.
- Газар зохион байгуулалтын төлөвлөлт: Шинэжинст сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Баян Хөндий ил уурхай болон түүнтэй холбоотой дэд бүтцийг байгуулахад шаардлагатай 100 га газрыг газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулж, баталсан.

Хайгуулын хөтөлбөр

2019 оны 4-р улиралд Компани нь Улаан болон Алтан Нар тусгай зөвшөөрлийн талбайд алмазан өрөмдлөгийн хөтөлбөр хэрэгжүүлж, Хөндий тусгай зөвшөөрлийн талбай дахь өндөр агуулга бүхий Хар Морь талбайд нарийвчилсан гадаргын хайгуулын хөтөлбөр хэрэгжүүллээ.

- Алтан Нар (Алт, Мөнгө, Хар тугалга, Цайр): 2020 онд Алтан Нар төсөлд томоохон хэмжээний хайгуул ба техникийн тооцооллын хөтөлбөрийг гүйцэтгэхээр төлөвлөж байна. Энэхүү хөтөлбөрийг Нээлтийн Бүсэд өрөмдсөн 5 цооногийн үр дүн дээр тулгуурлан тодорхойлно. Хөтөлбөрийн зорилго нь гол бүсэд өндөр агуулга үргэлжилж байгаа болон судлын дагуу хүдэржилт үргэлжилж байгааг тодорхойлоход оршино.
- Хар Морь (Алт): 32.9 г/т алтны агуулгатай дээж илрүүлсэн Хар Морь талбай, түүнтэй залгаа орших Алтан Сум талбайд геохимийн дээжлэлт (хөрс ба чулуулаг), геологийн зураглал бүхий нарийвчилсан гадаргуун хайгуулыг хийж гүйцэтгэсэн, 2020 онд Хар Морь талбайд үргэлжлүүлэн хайгуул хийхээр төлөвлөсөн.
- Улаан (Зэс-Алт): UDH-02 (2018 оны 3-р улиралд өрөмдсөн) цооногийг 638 метр хүртэл сунгаж өрөмдөн, гол филлик хувирлын бүсийн доор порфирын холбоотой хүдэржилт байгаа эсэхийг шалгасан. Түүнээс гадна гол филлик хувирлын бүсийн захад орших серицит-кварц-турмалин брекчийн биед интрузив, эсвэл порфирын холбоотой орчин байгааг шалгах хоёр цооногийг өрөмдсөн.

Эдгээр хөтөлбөрүүдийн үр дүнг 2020 оны 1-р улирлын дундуур танилцуулахаар төлөвлөж байна.

Хөндий Алтны Төслийн тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-ээсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн террейнд байрладаг. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Эдгээр ордуудыг хамтад нь Хөндий Алтны Төсөл (“Төсөл”) хэмээн нэрлэдэг.

2019 оны 10 сард Эрдэнэ Ресурс нь Хөндий Алтны Төслийн техникийн тайланг (Хэвлэлийн мэдээтэй [эндээс](#) танилцана уу) танилцуулсан бөгөөд энэхүү техникийн тайланд Баян Хөндий ордын (“Bayan Khundii”) урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэл (“урьдчилсан ТЭЗҮ”, “PFS”) болон Алтан Нар ордын (“Altan Nar”) шинэчилсэн анхан шатны эдийн засгийн тооцоолол (“АШЭЗТ”) орсон болно. Урьдчилсан ТЭЗҮ-д Баян Хөндий, Алтан Нар ордын татварын дараах өнөөгийн цэвэр үнэ цэн (5% хорогдуулалтаар тооцоолж) (“NPV5%”) алтны үнийг \$1,300 ам.доллар/унц байхаар төсөөлөхөд тус бүр \$97 сая ам.доллар, \$24 сая ам.доллараар тооцоологдсон. Баян Хөндий ба Алтан Нарын дотоод өгөөжийн түвшинг (“IRR”) тус бүр 90%, 42% гэж тооцоолсон. Урьдчилсан ТЭЗҮ-д 0-7 жилд Баян Хөндий ордыг ашиглах ба 3.73 г/т дундаж агуулга бүхий хүдрийг боловсруулж, жилд дунджаар 61,000 унц алтыг илээр олборлох, 7-10 жилд Алтан Нар ордыг ашиглан, 3.46 г/т дундаж агуулга бүхий хүдрийг боловсруулж, жилд дунджаар 48,000 унц алт олборлохоор төлөвлөж байна. Баян Хөндий ордод уламжлалт нүүрсэнд уусган баяжуулах үйлдвэрийг байгуулахаар төлөвлөсөн. 2019 оны 8-р сард Баян Хөндий ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийг авсан бөгөөд компани 2021 оноос эхлэн үйлдвэрлэл эхлүүлэхээр төлөвлөж байна.

Анхан шатны эдийн засгийн тооцоолол нь урьдчилсан таамаглал бөгөөд зарим тооцоололд боломжит нөөц агуулсан. Боломжит нөөц нь урьдчилсан болон эцсийн техник, эдийн засгийн тооцоололд нөөц хэмээн багтаахад геологи, эдийн засгийн хувьд эрсдэл ихтэй. Эдийн засгийн үр ашиг багатай геологийн нөөцийг үйлдвэрийн нөөц, эдийн засгийн тооцоололд багтаахгүй.

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий 4 хайгуулын, 2 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүдэд давхар бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт www.erdene.com-оос авч танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээллийг авахыг зөвлөж байна.

Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмет спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screenmetallic gold

analysis) хийсэн ба энэ нь 500 г дээжний 75 микроноос бага байх 30 г бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцагт үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн хийж Улаанбаатар дахь Эс Жи Эс ("SGS") лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнийн ложистикийн гэрээт компани Монруд ХХК гүйцэтгэдэг.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь Англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, Монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал Англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал

Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>

YouTube: <https://www.youtube.com/channel/UCILs5s9j3SLmya9vo2-KXoA>